



МОНГОЛ УЛСЫН
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 2 дугаар зүйлийн 10-ын А, Е дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 18 дугаарт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгаар хэрэгжүүлэх Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх Хэлмэгдэгчдийн дурсгалын музей цогцолбор төслийн бэлтгэл ажлыг хангах, төрийн захиргааны байгууллагын дэмжлэг, оролцоог хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлах:	Э.Ариунбат	Улсын комиссын салбар комисс, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Л.Очирсүрэн	Улсын комиссын Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга
	Ж.Батбаясгалан	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд Цагаатгах ажлыг удирдан зохион Нийслэлийн салбар комиссын дарга,
	Д.Дашдулам	МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн Түүхийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D),
	Ч.Баатар	ЗГХЭГ-ын харьяа Удирдлагын Адемики Улсын салбарын удирдлагын тэнхимийн ахлах багш, докторант
	Ч.Өнөржаргал	"Төслийн удирдлага, хөгжлийн хүрээлэн" ТББ-ын судлаач, доктор
Нарийн бичиг:	Б.Батжаргал	Хэлмэгдэгсдийн Энхтайван Ирээдүй Сангийн УЗ-ын гишүүн, гүйцэтгэх захирал

2. Төслийн үйл ажиллагааны Ерөнхий төлөвлөгөөг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, төрийн холбогдох байгууллагуудын захиргааны дэмжлэгийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлах Э.Ариунбат, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Нийслэлийн салбар комиссын дарга Ж.Батбаясгалан нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрт даалгасугай.

ДАРГА



С ОДОНТУЯА

Улсын комиссын даргын 2023 оны 05 дүгээр сарын 03-ны өдрийн 07 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Улс төрийн Хэлмэгдэгчдийн дурсгалын музей цогцолбор
төслийн Ерөнхий төлөвлөгөө

2023 оны дүгээр сарын ...

Улаанбаатар хот

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Холбогдох ажлын хэсгийг байгуулах	2023 оны 4-р сарын эхний хагас	ЦАУЗБУК-ын ажлын алба
2	Холбогдох эрх зүйн акт, гэрээ боловсруулж батлуулах	2023 оны 3-р улирал гэхэд багтаах	Ажлын хэсэг
3	Музейн үндэслэл, тайлбар хийх	2023 оны 4-р сар	Ажлын хэсэг
4	Төслийн эхний танилцуулгыг боловсруулах, холбогдох гадаад хэл дээр бэлэн болгох	2023 оны 4, 5-р сар	Ажлын хэсэг
5	Төслийн танилцуулгад үндэслэн "Улсын салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т оруулах	2023 оны 2-р улиралд багтаах	Ажлын хэсэг
6	Урьдчилсан төслийн "Техник, эдийн засгийн үндэслэл"-ийн загвар боловсруулах	2023 оны 2-р улиралд багтаах	Ажлын хэсэг
7	Урьдчилсан төслийн "Техник, эдийн засгийн үндэслэл"-ийг боловсруулах гэрээ байгуулах	2023 оны 2-р улиралд багтаах	Ажлын хэсэг
8	Төслийн "Техник, эдийн засгийн үндэслэл"-ийг боловсруулж дуусгах	2023 оны 2-р улиралд багтаах	Ажлын хэсэг
9	Төрийн байгууллагуудаас төсөлд ач холбогдол бүхий судалгаа, мэдээллийг цуглуулах, боловсруулах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ЦАУЗБУК-ын ажлын алба, Нийслэлийн салбар комисс
10	Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр туршлага мэдээлэл солилцох, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах	2023 оны 4, 5-р сар, тухай бүр	ЦАУЗБУК-ын ажлын алба, Ажлын хэсэг
11	ЦАУЗБУК-ын нийт салбар комиссыг зохих хэлбэрээр татан оролцуулах, төлөвлөгөө боловсруулж, батлуулах	2023 оны 5-р сарын эхний хагас	ЦАУЗБУК-ын ажлын алба

ЦАГААТГАЛЫН УЛСЫН КОМИСС